

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Б.ЛУВСАНДОРЖИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”							
1	Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, холбогдох эрх зүйн актад нийцэж буй эсэхэд хяналт тавьсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	ГЕГ-аас батлан гаргах захиргааны хэм хэмжээний акт, захиргааны актын төслин хууль зүйн үндэслэл нь холбогдох хууль тогтоомжид нийцэх буй эсэхэд хяналт тавьж, санал өгсөн байх	1. “Хилийн боомтын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлд 1. 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг бүхэлд нь хасах саналтай байна. Учир нь Гаалийн тухай хуулийн 2 дугаар зүйлд “хууль тогтоомж”, 2 дугаар зүйлийн 2.1-д “Монгол Улсын гаалийн хууль тогтоомж нь Үндсэн хууль,Татварын ерөнхий хууль,энэ хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай, Хилийн боомтын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж заасан байна. 2. 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт “Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль” гэж нэмэх. Учир нь боомтоор мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхэд Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиар энэ харилцаа зохицуулагддаг. 4. 13 дугаар зүйлийн 13.5, 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалтуудыг тус тус хасах. Учир нь эдгээр харилцаа нь Гаалийн тухай хуулиар зохицуулагдсан тул давхардсан. 5. 14 дүгээр зүйлд хил хамгаалах байгууллагын чиг үүргийг нэмж тусгаж өгөх. Учир нь боомтоор нэвтрүүлэх үеийн хяналт шалгалтын байгууллагуудаас хил хамгаалах байгууллагын чиг үүрэг орхигдсон байгаа тухай саналыг тус хэлтсийн 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 99 дугаартай Боомтын хэлтэст хүргүүлсэн. 2. ГТЛ-с ирүүлсэн Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.27-д заасны дагуу дотоодын гэрээгээр борлуулсныг Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолд хамааруулах эсэх,	01.02-11.30	100

				Харьяа гаалийн газар, хорооны дарга нарын бүрэн эрхийн хүрээнд батлан гаргадаг тушаал, шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянаж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах	биржээр оруулахгүйгээр гаргах талаар зөвлөмж хүссэн 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 60 дугаартай дотоод зурвастай танилцаж Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосны дагуу Засгийн газар батална”, 10.2-т “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулах энэ хуулийн 10.1-д заасан уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр заавал арилжина”, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг батлах тухай” тогтоолын 223 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ...Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), ...даалгаж, 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн мөрдөхөөр заажээ. Дотоод зурваст хавсаргасан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 06/2914 дүгээр албан бичгийн агуулгаас үзэхэд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулиар “дотоодын зах зээлд” худалдаалсан төмрийн хүдрийг хэрхэн экспортлох талаар эрх зүйн зөвлөмж өгөөгүй байна. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-д хүргүүлсэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны 06/2914 дүгээр албан бичиг нь Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.27, 4.1.28, 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг хэрхэн хэрэгжүүлж ойлгохыг зөвлөснөөс бус Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолын талаар дурдаагүй байна. Иймд уг албан бичгийг Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолд хамааруулан үзэх боломжгүй” гэсэн саналыг тус хэлтсийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 95 дугаартай дотоод зурвасаар өгсөн. 1. Говь-Алтай аймгийн Бургастай дахь гаалийн хорооны 2024 оны 01 дүгээр сарын тушаалуудыг хянаад 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 01-1.2/881 дүгээр албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн. 2. Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын тушаалуудыг хянаад 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 01-1.2/880 дугаар албан бичгээр зөвлөсөн.		
--	--	--	--	--	--	--	--

2	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээ	Хэрэгжилт, гүйцэтгэл эр	-	УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэх	УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэх ажилд хамтран арга зүйн зөвлөгөө өгч ажилласан болно.	01.02-11.30	100
3	Хууль, хяналтын байгууллагад Гаалийн байгууллагыг төлөөлөх, хамтран ажилласан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэл эр		Захиргааны, Иргэний болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Гаалийн Ерөнхий Газрын даргын олгосон итгэмжлэлийн үндсэн дээр нэхэмжлэгч, хариуцагч, иргэний хохирогчоор оролцсон талаар, шүүх болон хууль хяналтын бусад байгууллагуудын шийдвэр, хүсэлтийн дагуу шинжээчийн дүгнэлт гаргах үйл ажиллагаанд хамтран ажилласан байна.	Тайлант хугацаанд захиргааны болон иргэний 10 хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажилласан байна. Тухайлбал: 1. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хянагдсан А.Гэрэлмаагийн нэхэмжлэлтэй, Гаалийн ерөнхий газарт холбогдох иргэний хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон. 2. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж байсан "Сити хөгжил" ХХК, "Тулга техник" ХХК, иргэн Д.Батбилэг нарын нэхэмжлэлтэй, Гаалийн ерөнхий газарт холбогдох иргэний хэрэг хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож шүүхэд ялалт байгуулсан. 3. "Техник импорт" ХК-ийн нэхэмжлэлтэй, Монгол Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам, Улаанбаатар хот дахь гаалийн газарт холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь эс зөвшөөрсөн тайлбарыг өгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Хишигбатад эрх зүйн зөвлөмж өгч ажиллаж байна. 4. "Санчир Ундрах" ХХК-ийн нэхэмжлэлтэй, Гаалийн ерөнхий газарт холбогдох захиргааны хэрэгт Гаалийн ерөнхий газрын Хяналт, бүрдүүлэлтийн газрын гаалийн улсын ахлах байцаагч Д.Ариунцэцэг, Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн гаалийн улсын байцаагч Ц.Урантуул, Хуулийн хэлтсийн гаалийн улсын байцаагч Б.Лувсандорж, Улаанбаатар хот дахь гаалийн газрын гаалийн улсын ахлах байцаагч	01.02-11.30	100

					Б.Болормаа, гаалийн улсын байцаагч Г.Гасан нар томилогдсон. Уг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байна. 5. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж буй Л.Байгалмаагийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 128/ШШ2024/0171 дүгээр шийдвэрээр Л.Байгалмаагийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. 6. О.Отгонбаярын нэхэмжлэлтэй, Гаалийн ерөнхий газрын даргад холбогдох захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож ялалт байгуулсан. 7. П.Мөнхсайханы нэхэмжлэлтэй, Гаалийн ерөнхий газрын даргад холбогдох захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож ялалт байгуулсан. 8. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж буй “Санчир-Ундрах” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Барааны ангилал, үнэлгээний хэлтэс, Бүрдүүлэлтийн цахим төвд холбогдох захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцж байна. 9. “Санчир-Ундрах” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар, Барааны ангилал үнэлгээний хэлтэст холбогдох захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байна. 10. “Чоногол трейд” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмж дэх гаалийн газарт тус тус холбогдох захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байна.		
4	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах	Хийгдэх ажлын шалтгаан, нөхцөл, суурь үзүүлэлтээр		Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана.	Тайлант хугацаад 4 удаа бодлогын баримт бичигт хэрэгжүүлэн ажилласан байна. Тухайлбал: 1. Шуурхай хуралдаанаас өгсөн үүргийн дагуу ГЕГ-ын 2024.02.01-ний өдрийн “Зарим хилийн боомтын талаар авах арга хэмжээний тухай А/105 дугаар тушаалын төслийг боловсруулж танилцуулан 2024 оны 02 дугар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Уг тушаалаар “Гаалийн байгууллагын удирдах ажилтны 2024 оны сургалт, зөвөлгөөн”-өөс гаалийн улсын байцаагч нарын ажлын ачааллыг тэнцүүлэхтэй холбоотой гаргасан санал, хүсэлтийг үндэслэн Гашуунсухайт, Шивээхүрэн дэх хилийн боомтуудын гаалийн улсын байцаагч нарыг 28 хоног ажиллуулж 14 хоног амраах хэлбэрээр ажиллах болон амралтын цагийг гаалийн улсын байцаагч тус бүрээр нарийвчлан хуваарь гарган зохицуулан ажиллуулж, Гашуунсухайт, Шивээхүрэн дэх гаалийн газрын гаалийн улсын байцаагч нарын ажил,	01.02-11.30	100

					амралтын цагийг дээрх зохицуулалтад шилжүүлсэнтэй холбоотойгоор хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны зааварчилгааг чанд сахиж ажиллахыг тус газрын дарга нарт даалгасан. 2. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/103 дугаар тушаалаар байгуулагдсан албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байна. 3. Шуурхай хяналтын төвийн 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 58 дугаартай дотоод зурвасаар ирүүлсэн “Заавар батлах тухай” тушаалын төсөл, “Гаалийн байгууллагын гомдол, мэдээлэл, лавлагааны тусгай дугаар ашиглах заавар”, “Санал, гомдол, мэдээлэл бүртгэх маягт”-ын төсөл нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд тус хэлтсийн мөн оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 182 дугаартай дотоод зурвасаар дараах санал, дүгнэлтийг хүргүүлсэн. 4. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн “Журам батлах тухай” 120 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааны журам”-ыг 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр e-cabinet.gov.mn-ээр хүлээн авч энэхүү тогтоолыг төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа мөрдөж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газарт тус хэлтсийн 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 474 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн.		
5	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт хангах	Хийгдэх ажлын шалтгаан, нөхцөл, суурь үзүүлэлтээр		Хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлж ажилласан талаар тайлагнана.	Тайлант хугацаанд дараах ЗББН-дэд хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлж ажилласан байна. Тухайлбал: 1. Харьяа гаалийн газар, хороодын дарга нарт “Гаалийн байгууллагаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Гаалийн байгууллагын удирдах ажилтны 2024 оны сургалт, зөвлөгөөн”-ний үеэр “1111” төвд “харьяа гаалийн газар, хороодын гаалийн улсын ахлах байцаагч нар гэж гаалийн газрын даргаасаа илүү эрх мэдэлтэй хүмүүс байна. Тус гаалийн ахлах байцаагч нарын доор гаалийн хяналт шалгалтын улсын байцаагч нар ажилладаг. Гэтэл тухайн хүмүүст долигонож байж ажил үүргээ гүйцэтгэх, бусдыг нь хясан боогдуулах, дарамт учруулах зэрэг асуудал үүсдэг. Замын-Үүд, Сэлэнгэ, Гашуунсухайт гаалийн газрын гаалийн улсын ахлах байцаагч нар нь ажил үүргээ сайн мэдэхгүй, сонгон шалгаруулалтаар албан тушаалд томилогдоогүй, төрийн ажлыг хуулийн хүрээнд хийж байгаа байцаагч нарт дарамт үзүүлдэг асуудлыг уг зөвлөгөөнд уламжилж өгөх”-ийг хүссэн гомдол ирсэн байна. Иймд харьяа гаалийн газар, хороодын дарга нар гаалийн улсын ахлах байцаагч нарын ажилдаа хандах хандлага, мэргэжил, ёс зүй, ур чадварыг үнэлж, удирдлагын зүгээс шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэн тайланг 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор	01.02-11.30	100

				ирүүлэх” чиглэлийг 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 02/316 дугаар албан бичгээр хүргүүлж хувийг 1111 төвд хүргүүлсэн. 2. Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/41 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг судлан үзээд Гаалийн ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01-1/394 дүгээр албан Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт, мөн оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01-1/393 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт “Юнайтед белаз машинери инвестмент” ХХК /6024181/-ийн холбогдох мэдээллүүдийг хүссэн. Албан бичгийн хариу одоогийн байдлаар ирээгүй байна. 3. Тус хэлтсийн 2024.02.14 64 дугаартай дотоод зурвасаар Гаалийн төв лаборатори, Эрсдэлийн удирдлагын хэлтэст “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн ТБ-131-12/471 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Хамтран ажиллах гэрээ”-ний төсөлд санал авч нэгтгэсэн. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай гэрээ байгуулагдсан. 4. Тус хэлтсийн 2024.02.14-ний өдрийн 65 дугаартай дотоод зуравсаар Тариф, татварын газарт “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам”-ын төсөлд санал өгсөн. 5. Тус хэлтсийн 2024.02.15-ны өдрийн 66 дугаартай Барааны аниглал, үнэлгээний хэлтэст Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03/151 дүгээр албан бичгээр Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай /шинэчлэн найруулга/-ийн хуульд заасны дагуу шинэчлэн боловсруулсан “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам”-ын төсөлд санал өгсөн. 6. Тус хэлтсийн 2024.02.16-ны өдрийн 68 дугаартай дотоод зурвасаар Статистик, дүн шинжилгээний хэлтэст Зам, тээврийн хөгжлийн яамны 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 04/541 дүгээр албан бичгээр “Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ”-д Гаалийн ерөнхий газрын мэдээллийн системээс өгөгдөл, мэдээлэл дамжуулах, солилцох үйл ажиллагааг автоматжуулах “Хамтран ажиллах гэрээ” дээр ажилласан. Уг гэрээ одоо байгуулагдаж байна. 7. Хяналт, бүрдүүлэлтийн газарт тус хэлтсийн 2024.02.19-ний өдрийн 74 дугаартай дотоод зурвасаар “Алтан булаг чөлөөт бүсийн хөрөнгө оруулагчдын хөгжлийн бүс зөвлөл” ГҮТББ-ийн захирал Б.Орхоноос 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн “Асуудал шийдвэрлүүлэх тухай” 24/10 дугаартай албан бичгээр захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, Эдийн засгийн хөгжлийн сайдаас хүргүүлсэн чиглэлийг хэрэгжүүлэн, тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн		
--	--	--	--	--	--	--

					нэгжүүдийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоогоор шуурхай хангаж өгөхийг хүссэн хүсэлтэд хариу, эрх зүйн зөвлөмж өгсөн. 8. Хүний нөөцийн хэлтэст тус хэлтсийн 2024.02.19-ний өдрийн 73 дугаартай дотоод зурвасаар нэгэнт тэтгэвэрт гарсан иргэнийг “ажил гүйцэтгэх гэрээ”-ээр цалин хөлс, урамшууллыг нь тохиролцсоны үндсэн дээр ажиллуулж болох бөгөөд энэ тохиолдолд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох эрх зүйн үндэслэлгүй гэж зөвлөсөн. 9. Гаалийн төв лабораторит тус хэлтсийн 2024.02.23-ны өдрийн 85 дугаартай дотод зурвасаар “Монголросцветмет” ТӨҮГ-ын Гаалийн ерөнхий газарт хандсан 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1/352 дугаар албан бичиг, “Монголын хөрөнгийн бирж” ХХК-ийн зүгээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Санхүүгийн зохицуулах хороонд хандсан 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 01/110 дугаартай албан бичигт үндэслэн хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөсөн. 10. Гаалийн ерөнхий газрын зүгээс “Оюу толгой” ХХК-тай гэрээ байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд Гашуунсухайт дахь гаалийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Ганбаярт “Гаалийн ерөнхий газрын зүгээс “Оюу толгой” ХХК-тай гаалийн салбар лаборатори байгуулах, лабораторийн магадлан шинжилгээ хийх, гаалийн хяналт, бүрдүүлэлт хийх, гаалийн улсын байцаагч, шинжээчийг ажилдаа ирэх болон буцах тээврийн асуудал, ажлын байрны нөхцөл зэрэг шаардлагатай бүхий л асуудлыг тусгасан “Хамтран ажиллах” цогц гэрээ байгуулахаар уулзалт зохион байгуулсан. Үүний үр дүнд Оюу толгой ХХК Гаалийн ерөнхий газрын хороонд гэрээ байгуулагдсан. 11. Санхүү, хөрөнгө газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 30 дугаартай дотоод зурвасыг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр хүлээн авч танилцаад “Гаалийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан тоног төхөөрөмжүүдийг Орхон аймаг дахь гаалийн газрын балансаас “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын балансад шилжүүлж болох эсэхэд манай хэлтсийн зүгээс тусгайлан эрх зүйн зөвлөмж өгөх боломжгүй байна. Иймд энэ талаарх асуудлыг Сангийн яаманд уламжлаж шийдвэрлүүлэхийг хүсье” гэж холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг хүрээнд зөвлөмж өгч ажилласан. 12. Гаалийн ерөнхий газар болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хооронд байгуулагдах “гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах” гэрээний төсөлтэй танилцаж эрх зүйн зөвлөмжийг тус хэлтсийн 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 113 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн. 13. Эрсдэлийн удирдлагын хэлтсийн 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 2024/85 дугаартай дотоод зурвастай танилцаад “Гаалийн		
--	--	--	--	--	---	--	--

				ерөнхий газар Зорчигчийн мэдээллийн төвийн хооронд байгуулагдах “Мэдээлэл харилцан солилцох тухай гэрээ”-ний төсөлд тус хэлтсийн зүгээс тусгайлан өгөх саналгүй болно” гэдгийг тус хэлтсийн мөн оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 179 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн. 14. Чингис Хаан Олон Улсын нисэх буудал дахь гаалийн газарт тус хэлтсийн мөн оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 01-1.2/2025 дугаартай албан бичгээр тухайн сарын ажлын үр дүнгийн үзүүлэлтийг уг тушаалтай холбогдуулан тооцох нь зөв” гэсэн зөвлөмж, чиглэлийг өгсөн. 15. Тус хэлтсийн 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 233 дугаартай дотоод зурвасаар Аж ахуй, үйлчилгээний албанд Гэрээт ажиллагчид ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан эсхүл аман гэрээ болон хоёр талын тохиролцоогоор ажилладаг, хөдөлмөрийн харилцаа нь Иргэний хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжоор зохицуулагддаг, ажил олгогчдод ажил, үйлчилгээ үзүүлснийхээ төлөө мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс, урамшуулал авдаг байнгын ажилтанд хамаарахгүй иргэнийг хамруулна” гэсэн зөвлөмжийг өгсөн. 16. Хүний нөөцийн хэлтсийн 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 156 дугаартай дотоод зурвас, түүнд хавсаргасан Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын Хяналт, шалгалтын албаны Хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч Ц.Батсүхийн Гаалийн ерөнхий газрын даргад гаргасан хүсэлттэй танилцаад Гаалийн улсын ахлах байцаагч Ц.Батсүхийн хүсэлтийн агуулгаас үзэхэд хоёр төрлийн агуулгатай хүсэлт гаргасан байх бөгөөд дараах байдлаар эрх зүйн зөвлөмжийг тус хэлтсийн 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 243 дугаартай дотоод зурвасаар хүргүүлэн холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг хүрээнд хэрэгжүүлж ажиллаж байна.		
6	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэл эр	1. Нэгжийн дотоод эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулсан байна.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх хүрээнд судлан үзээд 1. Хүний нөөцийн буруу бодлогын хүрээнд өсөн нэмэгдэж буй ажлын цар хүрээг хүний болон санхүүгийн нөөцтэй уялдуулан хүний нөөцийг зөв байлгах талаар санаачлах, 2. Албан тушаалын тодорхойлолт, чиг үүрэгт хамаарахгүй үүрэг даалгавар хүлээн авахгүй байх, өгсөн үүргийг ажлын ачлаалал болгохгүй цаг хугацаанд зэрэг гүйцэтгэх, 3. Мэргэжлийн мэдлэг сул, ажил гүйцэтгэх чадваргүй байдал, ажлын хариуцлагагүй, ёс зүйгүй үйлдэл гаргахгүй, мэдээллийг хугацаа хоцроох, буруу, алдаатай дамжуулсан зөрчил гаргахгүй байхыг олж харсан.	01.02-11.30	100

					4. Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эрсдэлийг бууруулах тусгайлсан төлөвлөгөө"-ний ажлын хүрээнд батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хангаж, биелэлтийг сарын бүрийн сүүлийн долоо хоногийн даваа гараг бүр тогтмол тайлагнаж байх ажлын хүрээнд тус хэлтсийн зүгээс хийсэн ажлын тайланг Захиргааны удирдлагын газарт тус хэлтсийн 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 469 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн.		
7	Үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах	Хэрэгжилт, гүйцэтгэл эр, хувиар	-	1.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд хуулийн хүрээнд тухай бүр хэрэгжүүлэн ажиллана.	Тайлант хугацаанд удирдлагаас өгсөн 26 удаагийн үүрэг даалгаврыг цаг хугацаанд хуулийн хүрээнд тухай бүр хэрэгжүүлэн ажилласан байна. Тухайлбал: 1. Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар, Барааны ангилал, үнэ үнэлгээний хэлтсээс Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 01/4581 дугаартай албан бичгээр “Санчир-Ундрах” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрын нэр бүхий гаалийн улсын байцаагч нарт холбогдох захиргааны хэрэгт нотлох баримт шаардсан байна. Иймд уг албан бичгийн 2, 3 дахь хэсэгт заасан нотлох баримт болон бусад шаардлагатай гэсэн баримтуудыг тус хэлтэст ирүүлэхийг мөн оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 241, 242 дугаартай дотоод зурвасаар авч шүүхэд хүргүүлсэн. 2. Захиргааны удирдлагын газар, Хяналт бүрдүүлэлтийн газар, Зөрчилтэй тэмцэх газар, Хорио цээрийн хэлтэс, Статистик, дүн шинжилгээний хэлтэс, Боомтын хэлтсээс Хилийн боомтын захиргааны 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 24/153 дугаартай албан бичгээр “Мэдээлэл солилцож хамтран ажиллах тухай гэрээ”-ний төсөлд санал авч нэгтгэн Дэд даргад танилцуулж хүргүүлэхэд бэлэн болоод байна. 3. Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийн дагуу тус шүүхэд “Морь экспрес” ХХК-ийн гаалийн бүрдүүлэлтийн мэдээг Статистик, дүн шинжилгээний хэлтсээс гаргуулан нийт 7 хуудас баримтыг мөн оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 01-1.2/2109 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. 4. Санхүү, хөрөнгө оруулалтын газрын 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 79 дугаартай дотоод зурвасыг мөн оны 05 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авч танилцаад “Гаалийн ерөнхий газар болон “Нанопланет” ХХК-ийн хороонд байгуулагдах “Хүний биеийн халуун хэмжигч, металл мэдрэх зориулалттай гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмж /Улсын хэмээнд/ нийлүүлэх гэрээ”-ний төсөлд хууль эрх зүйн хувьд тусгайлан өгөх саналгүй болно гэж тус хэлтсийн мөн оны 05 дугаар сарын 29-ны өдрийн дотоод зурвасаар хүргүүлсэн. 5. Аж ахуй, үйлчилгээний албанаас ирүүлсэн “Монгол хьюндай автомотив” ХХК-тай байгуулах “Авто машины засвар үйлчилгээ хийх	01.02-11.30	100

				гэрээ”, “Эл даблью органик футур ар” ХХК-тай байгуулах “Худалдах худалдан авах гэрээ”-ний төсөлтэй танилцаад 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 246 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн. 6. Статистик, дүн шинжилгээний хэлтсээс Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 4-190/1781 дугаар албан бичгээр “Цахиур хангайн хүлэг” /РД:5371724/ ХХК-ийн 2015 оны 01 дүгээр сараас өнөөдрийг хүртэлх хугацаанд хийсэн гаалийн бүрдүүлэлтийн дэлгэрэнгүй лавлагаа, мэдээллийг хүссэн тул тус хэлтсийн 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 40 дугаартай дотоод зурвасаар хүргүүлж хариуг хүлээн авсан. 7. Бүрдүүлэлтийн цахим төвд Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 4-190/1781 дугаар албан бичгээр “Цахиур хангайн хүлэг” /РД:5371724/ ХХК гаалийн бүрдүүлэлт хийхээр гаалийн байгууллагад хандах бүрт хариуцсан тойргийн шийдвэр гүйцэтгэгч /89086190/-д нэн даруй мэдэгдэн хамтран ажиллахыг хүссэн. Иймд тухайн “Цахиур хангайн хүлэг” /РД:5371724/ ХХК гаалийн бүрдүүлэлт хийхээр гаалийн байгууллагад хандсан тохиолдолд Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хариуцсан тойргийн шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэн хамтран ажиллахыг 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 41 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн. 8. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх гарын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 4-190/1781 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Статистик, дүн шинжилгээний хэлтсээс “Цахиур хангайн хүлэг” /РД:5371724/ ХХК 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны мэдээлэл гаалийн мэдүүлгийн санд бүртгэгдээгүй болохыг тодруулан цаашид “Цахиур хангайн хүлэг” /РД:5371724/ ХХК гаалийн бүрдүүлэлт хийхээр хүсэлт гаргасан тохиолдолд танай байгууллагад мэдэгдэн хамтран ажиллахыг болохыг 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01-1/.2/313 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 9. Тус хэлтсийн 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 52 дугаартай дотоод зурвасаар Хяналт, бүрдүүлэлтийн газар, Татвар, орлогын газарт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03/151 дүгээр албан бичгээр Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай /шинэчлэн найруулга/-ийн хуульд заасны дагуу шинэчлэн боловсруулсан “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам”-ын төсөлд санал авч байгаа тул уг саналтай танилцаж 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 17 цаг 00 минутаас өмнө санал авсан.		
--	--	--	--	--	--	--

					10. Тус хэлтсийн 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 51 дугаартай дотоод зурвасаар Хяналт, бүрдүүлэлтийн газар, Мэдээллийн технологийн газар, Гаалийн төв лаборатори, Бүрдүүлэлтийн цахим төвд Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбатын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03/323 дугаар албан бичгээр Засгийн газрын 2015 оны 502 дугаар дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүний жагсаалт”-ыг хэрхэн хэрэгжүүлж ажиллах тухай албан бичгийг Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимидсүрэнд хүргүүлсэн албан бичигтэй танилцаж өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллахыг зөвлөсөн. 11. Гаалийн ерөнхий газрын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 01-1.2/443 дугаартай албан бичгээр “Говийн хан транс” ХХК-ийн гаргасан хүсэлтийг хариу өгсөн. 12. Тус хэлтсийн 2024.02.14-ний өдрийн 63 дугаартай дотоод зуравсаар Захиргааны удирдлагын газарт Хуулийн хэлтсийн 2024 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хүргүүлсэн. 13. “Ититнатитур” ХХК болон нэр бүхий компаниудын нэхэмжлэлтэй, Гаалийн ерөнхий газарт холбогдох захиргааны хэрэгт Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс ирсэн 2024.02.19-ний өдрийн 2/0389 дүгээр албан бичгийг хүлээн авч танилцаад Гаалийн ерөнхий газрын 2024.02.20-ний өдийн 01-1.2/622 дугаартай албан бичгээр “Гаалийн ерөнхий газрын зүгээс 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 03/352 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүх хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 5411 дугаарт бүртгэлтэй Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/223 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг хилээр нэвтрүүлэх журам”-д зохих өөрчлөлт хийлгэхээр хандсан бөгөөд Хууль зүйн, дотоод хэргийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 1/680 дугаар албан бичгээр уг журамд холбогдох хөдөлгөөн хийсэн тухай мэдэгдсэн болно” гэсэн хариуг өгсөн. 14. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж буй Л.Байгалмаагийн нэхэмжлэлтэй, Гаалийн ерөнхий газарт холбогдох захиргааны хэрэгт 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 1/1573 дугаар албан бичгийн дагуу тус газрын Хүний нөөцийн хэлтсээс тодруулахад “2022-2023 онд Улаанбаатар хот дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч Л.Байгалмаад өндөр насны тэтгэвэрт гарах тухай мэдэгдэл хүргүүлсэн. 15. “Тоёота сэйлс Монголиа” ХХК-ийн 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн ТМОН-64/2024 дугаартай албан бичигтэй танилцаад		
--	--	--	--	--	--	--	--

					автомашинуудын “Таван Богд” ХХК, “Мөнххада” ХХК, “Топ Моторс” ХХК импортолсон бол мэдээллийг тус компаниудаас гаргуулан авах боломжтой гэсэн хариуг 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01-1.2/948 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 16. Тус хэлтсийн 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 125 дугаартай дотоод зурвасаар Санхүү, хөрөнгө оруулалтын газар, Хүний нөөцийн хэлтэст Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 128/ШШ2024/0171 дүгээр шийдвэрийг биелүүлэх арга хэмжээ авч ажиллах”-ыг хүссэн. 17. Тус хэлтсийн 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 123 дугаартай дотоод зурвасаар Барааны ангилал, үнэлгээний хэлтсээс “Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 1/2462 дугаартай албан бичгээр “Санчир-Ундрах” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Гаалийн ерөнхий газрын дарга, Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн дарга, Улаанбаатар хот дахь гаалийн газар, гаалийн улсын ахлах байцаагч Б.Болормаа, Д.Ариунцэцэг, гаалийн улсын байцаагч Г.Гасан нарт холбогдох захиргааны хэрэгт нотлох баримт шаардсан байна. 18. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 1/3272 тоот албан бичигтэй танилцаад Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн Зүйл 90.18-д холбогдох тусгайлсан Тайлбар дүрэм гэж байдаггүй бөгөөд 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 01-1.2/1120 тоот албан бичгээр маргаанд ач холбогдол бүхий Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай олон улсын конвенци, Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн Ерөнхий тайлбар 6 дүрмийг нотлох баримтын шаардлага хангуулан хүргүүлсэн. 19. Санхүү, хөрөнгө оруулалтын газрын 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 70 дугаартай дотоод зурвасаар ирүүлсэн Гаалийн ерөнхий газар болон “Аз болор мөнх трейд” ХХК-ийн хороонд байгуулагдах “Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Эрэлч нохойн сургалтын төвийн эрэлч нохдыг зориулалтын нохойн хоолоор хангах, худалдан авах гэрээ”-ний төслийг хянаад “хууль эрх зүйн хувьд тусгайлан өгөх саналгүй” тус хэлтсийн мөн оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 191 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн. 20. Аж ахуй, үйлчилгээний албаны 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 30 дугаартай дотоод зурвасаар ирүүлсэн “Ариун хивс цэвэрлэгээ” ХХК, иргэн Б.Цэнгүүн нартай байгуулах “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний төслүүдийг хянаад мөн оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 185 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн. 21. Статистик, дүн шинжилгээний хэлтсээс Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн “Шүүх хуралдааныг хойшуулах тухай”	
--	--	--	--	--	---	--

					101/ШЗ2024/14170 дугаартай захирамжаар Гаалийн ерөнхий газраас “Морьт экспрес” /6284191/ ХХК нь 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр үржлийн 3 настай цэвэр үүлдрийн хүрэн зүстэй Франк нет нэртэй адууг Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн эсэх талаарх баримтыг шаардсан. Иймд тус “Морьт экспрес” /6284191/ ХХК-ийн 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өнөөдрийг хүртэлх гаалийн бүрдүүлэлтийн мэдээ, мэдээллийг ирүүлэхийг тус хэлтсийн 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 223 дугаартай дотоод зурвасаар хүлээн авч шүүхэд хүргүүлсэн. 22. “Санчир-Ундрах” ХХК-ийн зүгээс гаалийн улсын байцаагч, гаалийн улсын ахлах байцаагч цаашлаад гаалийн байгууллагын нэр хүн хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдсан, албаны нэр хүндэд харшилсан утга, агуулга бүхий гомдлыг удаа дараа гаргаж байгаатай холбогдуулан Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэс, Хорио цээрийн хэлтэс, Зөрчилтэй тэмцэх газар, Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар, Барааны ангилал, үнэлгээний хэлтэст гомдлыг танилцуулах, зөрчлийг шалган шийдвэрлэх хуралдааныг томилогдсон ГУБ ГУАБ нарыг оролцуулан танилцуулга зохион байгуулсан. 23. Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Билгүүнээс С.Нарангоод дахин таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан эсэх талаар тодруулгыг 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 01-2./4431 дүгээр албан бичгээр хандсан. 24. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт А.Гэрэлмаа, Б.Нацагням, Ц.Одоонтунгалаг нарын ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй холбоотой төлбөрийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ бусадд учруулсан хохирлыг барагдуулах сан”-аас төлүүлэхээр хамтран ажиллах хүсэлтийг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 01-1.2/4462 дугаартай албан бичгээр хандсан. 25. 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 01-1.2/4234 дугаар албан бичгээр Ц.Одонтунгалагийн 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх ажилгүй байсан хугацааны цалин, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооллыг Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газраас ирүүлснийг хавсралтаар хүргүүлсэн. 26. “Мон майнинг сертифицикэйшин” ХХК-ийн 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/24-120 дугаар албан бичгийг хүлээн авч “Мэдээллийн аюулгүй байдлын аудит”-ын үйлчилгээ үзүүлдэг үйл ажиллагааны чиглэлтэй танилцаад “Манай байгууллага цаашид хэрэгцээ шаардлага үүсмэгц “Мэдээллийн аюулгүй байдлын аудит”-ын үйл ажиллагааны чиглэлээр танай байгууллагатай хамтран ажиллах болох”-ыг 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 01-1.2/4219 дугаартай албан бичгээр уламжилсан.		
--	--	--	--	--	--	--	--

8	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Ажлын цаг ашиглалт суурь түвшнээс сайжруулж ажиллаж, үр дүнг тайлагнана.	Гаалийн улсын байцаагч Б.Лувсандорж би 2024 онд чөлөө аваагүй нь бүрэн ажилласан болно.	01.02-11.30	100
9	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1.Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна.	1. Тус хэлтсийн 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 104 дүгээр дотоод зурвасаар Захиргааны удирдлагын газар, Хяналт, бүрдүүлэлтийн газар, Татвар, орлогын газар, Зөрчилтэй тэмцэх газар, Санхүү хөрөнгө, оруулалтын газар, Хүний нөөцийн хэлтэс, Барааны ангилал, үнэлгээний хэлтэс, Мэдээллийн технологийн газар, Гаалийн төв лаборатори, Бүрдүүлэлтийн цахим төвөөс “Гаалийн ерөнхий газрын зүгээс “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай лабораторийн магадлан шинжилгээ хийх, бараанаас сорьц, дээж авах, загвар авах, шинжилгээний үр дүн болон лабораторийн дүгнэлт гаргах, баяжмалын тохирлын гэрчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулах цахим системд автоматаар байршуулах, гаалийн хяналт, бүрдүүлэлт хийх, гаалийн улсын байцаагч, шинжээчийн ажлын байрны нөхцөл, зөрчлөөс урьдчилсан сэргийлэх зэрэг шаардлагатай бүхий л асуудлыг тусгасан “Хамтран ажиллах” цогц гэрээ байгуулахаар уулзалт зохион байгуулан ажиллаж байна. 2. Улаанбаатар хот дахь гаалийн газрын Эрсдэлийн удирдлагын албаны эрсдэлийн удирдлага хариуцсан гаалийн улсын ахлах байцаагчаар ажиллаж байсан С.Нарангоогийн гаргасан хүсэлтийг судлан үзээд Хүний нөөцийн хэлтэст тус хэлтсийн 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 448 дугаартай дотоод зурвасаар “...Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн Б/461 дүгээр тушаалыг хүчингүй болгох боломжтой тул хамтран ажиллахыг хүсье. 3. Тус хэлтсийн 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 447 дугаартай дотоод зурвасаар ТОГ, БАҮХ-с Эрчим хүчний сайдын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн а/3133 дугаар албан бичгээр ирүүлсэн “Гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэгийн жагсаалт”-д сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй хослон ажиллах эрчим хүч хуримтлуурыг нэмж тусгахаар Засгийн газрын тогтоолын төсөлд санал авсан. Саналыг БАҮХ нэгтгэн Сангийн яаманд хүргүүлсэн. 4. Монгол Улсын шадар сайд Т.Доржхандын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн ЗГ-3/234 дугаартай албан бичгээр ирүүлсэн	01.02-11.30	100

					Монгол Улсын Ерөнхий сайдаас Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах, Улсын Их Хуралд өргөн барих ажлын хэсгийг бүрэлдэхүүнд ажиллах албан тушаалтны нэрийг ирүүлэх хүсэлттэй танилцаад уг хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт Гаалийн ерөнхий газрыг төлөөлж Гаалийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Тамирааг оролцуулах болсныг 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 01/4097 дугаар албан бичгээр уламжилсан. 5. “Санчир-Ундрах” ХХК-ийн 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 01/362 дугаартай албан бичгээр гаргасан “4 дэх удаагаа хариу хүсэж гомдол гаргах нь” гэсэн утга бүхий гомдолтой танилцаж, холбогдох баримтыг судлан үзээд “...Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь Гаалийн тухай хуулийн 275 дугаар зүйлийн 275.1.3-д “энэ хуульд зааснаас бусад мэдээлэл шаардах, иргэдэд чирэгдэл учруулах, бусдад давуу байдал олгох зэргээр ялгаварлах” гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй болох”-ыг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/4153 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 6. Зөрчилтэй тэмцэх газарт “Гадаад харилцааны сайдын 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 09/3803 дугаар албан бичгээр Катар Улстай өндөр, дээд түвшинд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй айлчлалын хүрээнд байгуулах баримт бичгийн явцыг урагшлуулах, эцэслэн тохиролцох ажлын хүрээнд “Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслалцаа үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Катар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн катарын талын хариу төслийг хянаад тус хэлтсийн 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 319 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн. 7. Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 142 дугаартай дотоод зурвастай танилцаад “Монгол Улсын Гаалийн ерөнхий газар БНХАУ-ын гаалийн байгууллагын хороонд зохион байгуулагдах удирдах түвшний албан ёсны уулзалтын төлөвлөгөөнд эрх зүйн саналыг тус хэлтсийн 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 318 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн.		
10	Байгууллагын улирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэлийг	Тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянасан, хэрэгжилтийг	-	Харьяалагдах нэгж, харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааг чиг үүргийн хүрээнд удирдлага, арга зүйгээр хангана.	1. Гаалийн ерөнхий газрын зүгээс “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай лабораторийн магадлан шинжилгээ хийх, гаалийн хяналт, бүрдүүлэлт хийх, гаалийн улсын байцаагч, шинжээчийн ажлын байрны нөхцөл зэрэг шаардлагатай бүхий л асуудлыг тусгасан “Хамтран ажиллах” цогц гэрээ байгуулахад Орхон аймаг дахь гаалийн газарт чиг гутхайн гэрээний тухай удирдлага арга зүйгээр хангаж ажилласан. 2. Зөрчилтэй тэмцэх газрын газрын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 189 дугаартай дотоод зурвастай танилцаад Гаалийн	01.02-11.30	100

	хянаж, хэрэгжилтийг хангах	хангасан байх - Тайланд нотломжийг хавсаргасан байх			байгууллага нь Гаалийн тухай хуулийн 269¹ дүгээр зүйлийн 269¹.1.11-д “улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх” гэж заасныг хэрэгжүүлдэг бөгөөд чөлөөлт эргэлтэд байгаа хүнсний бүтээгдэхүүнийг борлуулах явцад гарсан зөрчил, гарсан зөрчлийг шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх зүйн зохицуулалт байхгүй байна” гэсэн эрх зүйн зөвлөмжийг тус хэлтсийн 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 108 дугаартай дотоод зурвасаар өгсөн. 3. Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01/812 дугаартай албан бичигтэй танилцаад А.Гантулга /РД:ШЕ68100474/-ийн оршин суугаа хаягийг нь тодруулах боломжтой болох”-г 2024.10.03-ны өдрийн 01-1.2/4065 дугаартай албан бичгээр зөвлөсөн. 4. Чингис Хаан Олон Улсын нисэх буудлын 2 дугаар давхрын олон улсын явагчдын хүлээлгийн танхимд жоргүй олгодог эм, аминдэм, ариун цэврийн бүтээгдэхүүн, хүүхэд асаргааны бүтээгдэхүүн зэргийг борлуулах эмийн сангийн автомат вендинг машин байрлуулах, өдөр тутмын үйл ажиллагааг эмийн сангийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар гүйцэтгүүлэхэд Гаалийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гарсан эрх зүйн акттай харшлахгүй, хязгаарласан зохицуулалт байхгүй гэсэн зөвлөмжийг 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 355 дугаартай дотоод зурвасаар өгсөн. 5. Тус хэлтсийн 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 326 дугаартай дотоод зурвасаар Хяналт, бүрдүүлэлтийн газар, Татвар орлогын газар, Зөрчилтэй тэмцэх газар, Эрсдэлийн удирдлагын хэлтэст “Гаалийн ерөнхий газрын удирдлагын зүгээс өнөөдөр буюу 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 16 цагт Гаалийн ерөнхий газар “Монгол шуудан” ХК-ийн хооронд байгуулагдах “Хамтран ажиллах санамж бичиг”-ийг холбогдох нэгжээс санал авч саналыг нэгтгэн эрх зүйн зөвлөмжийг ЗТГ-т өгсөн. Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, “Монгол шуудан” ХК-ийн хоорондын “Хамтран ажиллах санамж бичиг” байгуулагдсан. 6. Тус хэлтсийн 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 313 дугаартай дотоод зурвасаар Засгийн газрын 2016 оны 209 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Импортын барааны гарал үүслийн дүрэм”-ийн 5.6, 5.7, 5.8 дахь заалт нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгтэй зөрчилдөхгүй бөгөөд уг дүрмийн Зургаа. “Гаалийн татварын зөрүүг шийдвэрлэх”-ийн 6.1 дэх заалтыг мөрдлөгө болгоно” гэсэн эрх зүйн зөвлөгөөг Бүрдүүлэлтийн цахим төвд өгсөн. 7. Тус хэлтсийн 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 305 дугаартай дотоод зурвасаар “Төрийн албаны тухай хууль, Гаалийн		
--	----------------------------------	--	--	--	---	--	--

					тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гарсан бусад эрх зүйн актаас үзэхэд “Оюу толгой” ХХК-тай шууд гэрээ байгуулах боломжгүй, хуульд нийцүүлэн тендер зарлаж “Оюу толгой” ХХК-ийг тендерт урилгаар оролцуулах эсхүл Сангийн яамнаас албан ёсоор бичгээр хариу авсны үндсэн дээр “Оюу толгой” ХХК-тай гэрээ байгуулах эсэхийг шийдвэрлэх нь зөв” гэсэн эрх зүйн зөвлөмжийн Санхүү, хөрөнгө оруулалтын газарт өгсөн.		
11	Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан дүрэм, журмыг Сангийн сайд, Засгийн газрын тогтоол шийдвэрээр хүчин төгөлдөр бус болгосон тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр болгох чиглэлээр хуульд нийцүүлэн дахин	Хүчин төгөлдөр бус болгосон дүрэм, журамд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байх; -Хуульд нийцүүлэн дахин боловсруулж, батлуулж мөрдүүлсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	-	1.Мөрдөгдөж байсан дүрэм, журмыг хүчин төгөлдөр бус болгосон тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хуульд нийцүүлэн дахин боловсруулах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	1 АТГ-ын ирүүлсэн 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 01/4936 дугаартай “Журам хянасан тухай” албан бичгийн дагуу ГЕГ-ын 2023 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан “Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан төсөл боловсруулж, Гаалийн байгууллагын https://customs.gov.mn цахим хуудсанд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 30 өдрийн хооронд байрлуулан, 2024.05.06-ны өдрийн онлайн хурлын үер үүрэг өгч харьяа гаалийн газар хороодоос албан бичгээр, ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудаас дотоод зурвасаар санал авч нэгтгэн ажиллав. Нийт 17 нэгжээс 46 санал ирсний 20 саналын утга, агуулга давхцсан бөгөөд 26 саналыг уг журмын төсөлд тусган батлуулахаар хүлээгдэж байна.	01.02-11.30	100


	боловсруулах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах						
--	---	--	--	--	--	--	--

боловсруулах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах							
---	--	--	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино, дунд хугацааны болон цахим сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор	-	Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна.	1. Удирдлагын академийн "Төрийн байгууллагын шийдвэр: хууль хэрэглээ" сэдэвээр 16 цагийн хичээл судлан хамрагдаж Үнэмлэх авсан. 2. Удирдлагын академийн "Төрийн албанд томилогдсон албан хаагчийн мэргэшүүлэх сургалт"-д хамрагдаж Үнэмлэх авсан.	01.02-11.30	100
2	Албан хэрэг хөтлөлтийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Бие дааж уншиж судалсан байна.	"Архивын тухай" хууль, "Монгол хэлний тухай" хууль, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан "Тамга тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам", Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн байгууллагад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх журам", Стандарт, хэмжилзүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан "Баримт бичиг стандарт MNS5140:2021" зэрэг баримт бичгийг тус тус уншиж судалснаар албан хэрэг хөтлөлтийн талаарх мэдлэгээ зохих түвшинд дээшлүүлсэн.	01.02-11.30	100

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХУУЛИЙН ХЭЛТСИЙН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ



Б.ЛУВСАНДОРЖ /

/ 2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР /

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Б.ЛУВСАНДОРЖИЙН 2024 ОНЫ
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Хуулийн хэлтэс

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 4: “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”					
1.	Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, холбогдох эрх зүйн актад нийцэж буй эсэхэд хяналт тавьсан байдал	60	10	70	69
2.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээ	60	10	70	60
3.	Хууль, хяналтын байгууллагад Гаалийн байгууллагыг төлөөлөх, хамтран ажилласан байдал	60	10	70	69
4.	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах	60	10	70	66
5.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт хангах	60	10	70	66
6.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	60	10	70	64
7.	Үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах	60	10	70	69
8.	Ажлын цаг ашиглалт	60	10	70	70
9.	Үндсэн шалгуурт тусагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангасан байна.	60	10	70	65
10.	Байгууллагын улирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянаж, хэрэгжилтийг хангах	60	10	70	64
11.	Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан дүрэм, журмыг Сангийн сайд, Засгийн газрын тогтоол шийдвэрээр хүчин төгөлдөр бус болгосон тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж,	60	10	70	62

цаашид үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр болгох чиглэлээр хуульд нийцүүлэн дахин боловсруулах, батлуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах				
Дундаж оноо:			70	65,8

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	14	14	14
2.	Япон хэлний анхан шатны мэдлэгтэй болох	14	14	8
Дундаж оноо:			14	11

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	7
2.	Асуудал шийдвэрлэх	7	6
3.	Хариуцлагатай байдал	7	7
4.	Дүн шинжилгээ хийх	7	7
5.	Ажлын цаг ашиглалт	7	7
Дундаж оноо:		7	6,8

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо:		8

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ


Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
-----	---------------------	--------------------------

1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	70
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	8
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	91,6
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ))- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		99

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга:

Хуулийн хэлтсийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

 (Ч.Тамираа)
2024.12.10 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:


Гаалийн улсын байцаагч

 (Б.Лувсандорж)
..... (огноо)

Үнэлгээг хянасан :


Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

 (Г.Энхтайван)
2024.12.10 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч

 (Ө.Тэгшээ)
2024.12.10 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч:

Гаалийн ерөнхий газрын дарга



(Р.Отгонжаргал)
..... (огноо)